



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар В/У16

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Онцгой  
байдлын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 64,582,600 /жаран дөрвөн сая таван зуун наян хоёр мянга зургаан зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс /А.Алтансүх/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 64,582,600 /жаран дөрвөн сая таван зуун наян хоёр мянга зургаан зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс /А.Алтансүх/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг хөрөнгийн үнэлгээ хийгдсэний дараа худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001007

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын  
даргын 2020 оны 07 дугаар сарын 30-өдрийн  
01/16 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Ашигла сан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ- ийн дүгнэлт	ЭБХХК- ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Уурын зуухны тоног төхөөрөмж	11	ш	1	3,460,000.00	3,460,000.00	3,460,000.00	0.00	эвдэрсэн	актлах	татах
2	Зуухны шүүлтүүр	1	ш	2	30,561,300.00	61,122,600.00	0.00	61,122,600.00	эвдэрсэн	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				3		64,582,600.00	3,460,000.00	61,122,600.00			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				3	-	64,582,600.00	3,460,000.00	61,122,600.00			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө				3	-	64,582,600.00	3,460,000.00	61,122,600.00			
Актлах хөрөнгө				-	-	-	-	-			